

**Аудитын код: САГ-2018/162/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)


Аудитор Д.Цэгмиддорж  
Утас: 261740 Цахим хаяг: [tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)



## Агуулга

---

|       |  |    |
|-------|--|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....  | 1  |
| 2     | Аудитын тайлан .....   | 3  |
| 2.1   | Оршил.....   | 3  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....             | 3  |
| 2.3   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....                 | 4  |
| 2.4   | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 4  |
| 2.5   | Дотоод хяналт.....   | 4  |
| 2.6   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....                             | 5  |
| 2.7   | Шилэн дансны мэдээлэл .....  | 5  |
| 2.8   | Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....                      | 6  |
| 2.9   | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....          | 6  |
| 2.9.1 | Авлагын талаар.....  | 6  |
| 2.9.2 | Үндсэн хөрөнгийн талаар .....  | 6  |
| 2.9.3 | Төсвийн зарцуулалтын талаар .....  | 6  |
| 2.9.4 | Урьдчилж төлсөн тооцооны талаар.....   | 7  |
| 2.10  | Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....                                       | 7  |
| 2.11  | Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....                                       | 7  |
| 2.12  | Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....  | 7  |
| 2.13  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....  | 7  |
| 2.14  | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....                       | 8  |
| 2.15  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....  | 8  |
| 3     | Менежментийн захидал.....  | 9  |
| 3.1   | Авлагын бүртгэлийн талаар.....   | 10 |
| 3.2   | Үндсэн хөрөнгийн талаар .....  | 11 |
| 3.3   | Төсвийн зарцуулалтын талаар .....  | 12 |
| 3.4   | Урьдчилж төлсөн тооцооны талаар.....   | 13 |
| 4     | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                        | 14 |
| 4.1   | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....                                    | 14 |
| 4.2   | Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....                                 | 16 |
| 4.3   | Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....                      | 18 |
| 4.4   | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                                     | 19 |
| 4.5   | Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                                  | 21 |



## 1 Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/458  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН  
САНГИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ИЧИНХОРЛОО  
ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын Үндэсний номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын Үндэсний номын сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



070452

### Үүрэг, хариуцлага

Монголын Үндэсний номын сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2018\0223SAG50.Docx

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Монголын Үндэсний номын сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монголын Үндэсний номын сангийн захиралын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ичинхорлоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /САГ-2018/162/СТА-ТШЗ/ Үндэсний аудитын газрын захиалгаар “Ньюбаланс Аудит” ХХК аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монголын Үндэсний номын сангийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.



Монголын Үндэсний номын сангийн 2017 оны санхүүгийн тайланг тус байгууллагын захирлын 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар албан бичгээр “Ньюбаланс Аудит” ХХК-д ирүүлсэн болно.

Монголын Үндэсний номын сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газартай байгуулсан YAГ/AA/2018-54 дугаартай гэрээний дагуу

2018 оны 1 дүгээр сарын 26-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн “Ньюбаланс Аудит” ХХК-ийн аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Б.Гэрэлмаа нар гүйцэтгэлээ.

### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголын Үндэсний номын сан 1921 онд Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд байгуулагдсан бөгөөд тайлант оны байдлаар 3.0 сая орчим ном хэвлэлтэй, 5 хэлтэс, 82 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн номын сангуудад мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг, дүрэм журам боловсруулах, мэргэжлийн ном, гарын авлага, ном зүйн бүтээлүүдийг бэлтгэн гаргах, номын санчдын сургалтыг зохион байгуулах зэргээр улсын хэмжээний бүх төрлийн 1500 гаруй номын санд зөвлөгөө өгч ажилладаг мэргэжил, арга зүйн төв байгууллага юм.

Тус байгууллага нь соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдлэг мэдээллээр үйлчлэх, түгээх, хойч үед өвлүүлэн үлдээх эрхэм зорилготой байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Монголын Үндэсний номын сангийн захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Монголын Үндэсний номын сан нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай 2017 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан уг гэрээний дагуу 993,247.6 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монголын Үндэсний номын сангийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс тус байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 20 нарийвчилсан горим, сорилуудыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acioius 3.0” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан бөгөөд цалингийн тооцоололд “Payroll” програмыг ашигладаг байна.

### 2.5 Дотоод хяналт

Монголын Үндэсний номын сангийн захирлын “Дотоод хяналт шалгалтын комиссыг шинэчлэх тухай” 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/24 дүгээр

тушаалаар орон тооны бус дотоод хяналтын ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Ингэснээр дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа тогтмолжиж, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, “Дотоод хяналт шалгалтын нийтлэг журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохих хэмжээнд хангаж байна.

Шинээр байгуулагдсан комисс Монголын Үндэсний номын сангийн “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг шинэчлэн захирлын 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлснээс гадна 2017 оны ажлын төлөвлөгөө гарган байгууллагын удирдлагаар батлуулан удирдамжийн дагуу дараах хяналтыг хийжээ. Үүнд:

- Ажил олгогчоос ажилтнуудтай хийсэн хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийх;
- Байгууллагын галын аюулгүй ажиллагаанд үзлэг хийж, дүгнэлт гаргах;
- Хөндлөнгийн байгууллагуудаас хийгдсэн хяналт шалгалт, үнэлгээний дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийх ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд тусгайлан шалгалт хийгдээгүй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр авлага өглөгийн насжилтийн судалгааг гаргаж, он дамжсан авлага, өглөгийг барагдуулах ажлыг зохион байгуулж цаашид авлага, өглөг гаргахгүй байхад анхаарч ажилласнаар авлагын үлдэгдлийг тайлант оны эцэст өмнөх оноос 45.3 хувиар буюу 5,025.1 мянган төгрөгөөр бууруулсан байна. Мөн өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн талаар эрх бүхий дээд байгууллагын удирдлагад танилцуулж, цаашид ашиглагдах боломжгүй 95,105.8 мянган төгрөгийн хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийн дагуу акталж устгасан байна.

## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монголын Үндэсний номын сан 2017 онд улсын төсвөөс 993,247.6 мянган төгрөгөөр санхүүжигдэхээр батлагдсанаас 983,528.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 27,505.0 мянган төгрөгийн үндсэн болон туслах үйлчилгээний орлого бүрдүүлэхээс 29,822.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

Батлагдсан төсвөөр 1,020,752.6 мянган төгрөгийг зарцуулахаас 1,022,485.2 мянган төгрөг зарцуулж, төсвийг 1,732.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь үндсэн болон туслах үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулсантай холбоотой байна.

Мөн нэмэлт төсвийн дансаар дээд шатны буюу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яам, Шинжлэх ухаан, технологийн сан зэрэг байгууллагуудаас ном худалдан авах зардал, бичиг үсгийн баяр, төслийн санхүүжилтэд нийт 69,924.5 мянган төгрөгийг авч зарцуулан тайлагнажээ.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Монголын Үндэсний номын сан 2017 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна. Тайлант онд тус байгууллага shilendans.gov.mn цахим санд хуулийн дагуу 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээний мэдээллийг байршуулж ажилласан байна. Тайлант онд тус байгууллагын

хувьд цахим санд 3 төрлийн мэдээллийг жил, улирал, сарын давтамжтай, нийт 150 мэдээллийг оруулах ёстойгоос 24 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 124 мэдээллийг хугацаа хожимдуулсан буюу засвар оруулан байршуулж, 2 мэдээлэл оруулаагүй хүлээгдэж байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөгөөр тогтоосон уламжлалт болон хяналтын эрсдэлүүдийг сорих батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Авлагын талаар

Тайлант оны санхүүгийн тайлангаарх авлагын үлдэгдэл /6,066.6 мянган төгрөг/-ийн 36.3 хувь буюу 2,202.7 мянган төгрөгийн авлага нь өмнөх онуудаас шилжин ирсэн үлдэгдэл бөгөөд үүнээс 664.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна


Шийдвэрлэсэн нь: Он дамжсан авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

### 2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тус байгууллагын санхүүгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй 18 нэр төрлийн 25 ширхэг 15,198.8 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.3-т “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах”, 14 дүгээр зүйлийн 14.2.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэж заасантай нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг акталж устгах талаар холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж ~~бүртгэлээс хасах~~ талаар зөвлөмж өгөх



### 2.9.3 Төсвийн зарцуулалтын талаар

Тус байгууллага нь 2017 оны батлагдсан төсвийг 1,732.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах, үндсэн болон туслах үйлчилгээний давсан орлогыг холбогдох шийдвэрийг үндэслэн зарцуулах.

#### 2.9.4 Урьдчилж төлсөн тооцооны талаар

“Түгээмэл шуурхай шуудан” ХХК-д 2018 оны хагас жилийн ном хэвлэлийн захиалгад урьдчилан төлсөн 2,369.7 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бус шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах талаар зөвлөмж өгөх.

#### 2.9.5 Нягтлан бодох бүртгэлийн талаар

2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 5 хоног хоцроож, аудитын байгууллагад ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох тухай албан шаардлага өгөх.

#### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

#### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### 2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Монголын Үндэсний номын сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 21,503.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба эдгээр зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах талаар байгууллагын удирдлагад 3 зөвлөмж, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

#### 2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал өмнөх оноос 57,836.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнийг үндэслэн материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн шатанд тус байгууллагын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл /1,180,431.7 мянган төгрөг/-ийн 2.0 хувиар тооцож 23,608.6 мянган төгрөгөөр тогтоолоо. Энэ нь төлөвлөлтийн шатанд тооцсоноос 1,156.7 мянган төгрөгөөр нэмэгдэж байгаа болно. /ТАБ-СТА-В1/

## **2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монголын Үндэсний номын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монголын Үндэсний номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

Үндэсний аудитын газрын захиалгаар “Ньюбаланс Аудит” ХХК-ийн гүйцэтгэсэн аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн Менежментийн захидлыг Монголын Үндэсний номын сангийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Монголын Үндэсний номын сангийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Бид эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монголын Үндэсний номын сангийн санхүүгийн болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.



**3.1 Авлагын бүртгэлийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант оны санхүүгийн тайлангаарх авлагын үлдэгдэл /6,066.6 мянган төгрөг/-ийн 36.3 хувь буюу 2,202.7 мянган төгрөгийн авлага нь өмнөх онуудаас шилжиж ирсэн үлдэгдэл бөгөөд үүнээс 664.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Он дамжсан авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Авлага төлөгдөх найдваргүй болох, санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, ашиглал шамшигдал үүсэх



**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

**3.2 Үндсэн хөрөнгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Тус байгууллагын санхүүгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй 18 нэр төрлийн 25 ширхэг 15,198.8 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.3-т “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах”, 14 дүгээр зүйлийн 14.2.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэж заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Ашиглалтгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг акталж устгах талаар холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж, бүртгэлээс хасах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.



**Эрсдэлүүд**

Хөрөнгийн дүн, санхүүгийн нөөц буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлан үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

### 3.3 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

### Тэргүүлэх ач холбогдол №3

#### ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь 2017 оны батлагдсан төсвийг 1,732.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

#### ҮАГ-ын зөвлөмж

Төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах, үндсэн болон туслах үйлчилгээний давсан орлогыг холбогдох шийдвэрийг үндэслэн зарцуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.



#### Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, бодит бус тооцоолол үүсэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

**3.4 Урьдчилж төлсөн тооцооны талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №4**

**ҮАГ-ын ажиглалт**

“Түгээмэл шуурхай шуудан” ХХК-д 2018 оны хагас жилийн ном хэвлэлийн захиалгад урьдчилан төлсөн 2,369.7 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бус шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчсөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Бэлтгэн нийлүүлэгчид үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн төлбөр тооцоог холбогдох тушаал, зааврын дагуу бүртгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөх талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.



Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

**4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| ДАНС       | БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ                 | ЭХНИЙ                   | ЭЦСИЙН                  |
|------------|-----------------------------------|-------------------------|-------------------------|
|            |                                   | ҮЛДЭГДЭЛ                | ГҮЙЦЭТГЭЛ               |
| 1          | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН           | <b>89,125,460.27</b>    | <b>95,776,362.98</b>    |
| 31         | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 0.00                    | 584,560.00              |
| 311        | Кассанд байгаа бэлэн мөнгө        | 0.00                    | 584,560.00              |
| 31110      | Төгрөг                            | 0.00                    | 584,560.00              |
| 312        | Банкинд байгаа бэлэн мөнгө        | 0.00                    | 0.00                    |
| 3121       | Төгрөг                            | 0.00                    | 0.00                    |
| 31211      | Төрийн сангийн харилцах           | 0.00                    | 0.00                    |
| 31214      | Бусад төсөл нөөцийн харилцах      | 0.00                    | 0.00                    |
| 33         | АВЛАГА                            | <b>11,091,730.27</b>    | <b>6,066,615.98</b>     |
| 33100      | Ажиллагсадтай холбогдсон авлага   | 7,373,270.00            | 665,350.00              |
| 335        | Бусад авлага                      | 3,718,460.27            | 5,401,265.98            |
| 3351       | Байгууллагаас авах авлага         | 1,053,447.87            | 3,558,557.58            |
| 3352       | Хувь хүмүүсээс авах авлага        | 2,665,012.40            | 1,842,708.40            |
| 34         | УРЬДЧИЛГАА                        | <b>22,541,000.00</b>    | <b>12,086,506.00</b>    |
| 34600      | Урьдчилж гарсан зардал            | 22,541,000.00           | 9,833,750.00            |
| 3471       | Урьдчилгаа тооцоо                 | -                       | 2,252,756.00            |
| 34714      | Томилолтын урьдчилгаа             | -                       | 2,252,756.00            |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>             | <b>55,492,730.00</b>    | <b>77,038,681.00</b>    |
| 351        | Түүхий эд материал                | -                       | 2,500,000.00            |
| 35110      | Тусгай зориулалттай материал      | -                       | 2,500,000.00            |
| 35300      | Бэлэн бүтээгдэхүүн                | 1,050,480.00            | 903,745.00              |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>        | <b>54,442,250.00</b>    | <b>73,634,936.00</b>    |
| 35410      | Бичиг хэргийн материал            | 27,152,146.00           | 34,570,342.00           |
| 35420      | Аж ахуйн материал                 | 4,380,004.00            | 4,235,664.00            |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл                   | 106,500.00              | -                       |
| 35440      | Түлш шатах тослох материал        | 191,000.00              | 18,000.00               |
| 35450      | Барилгын засварын материал        | 461,800.00              | 2,604,890.00            |
| 35470      | Бусад хангамжийн материал         | 22,150,800.00           | 32,206,040.00           |
| 2          | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН       | <b>4,947,576,104.44</b> | <b>4,928,558,923.76</b> |
| 39         | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                    | <b>5,036,701,564.71</b> | <b>5,024,335,286.74</b> |
| 392        | Биет хөрөнгө                      | <b>4,896,207,442.04</b> | <b>4,871,242,194.45</b> |
| 39201      | Барилга, байгууламж               | 1,847,690,019.00        | 1,847,690,019.00        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл             | (1,540,066,442.15)      | (1,568,141,828.87)      |
| 39203      | Авто тээврийн хэрэгсэл            | 51,800,000.00           | 51,800,000.00           |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл             | (35,517,499.53)         | (39,497,499.45)         |
| 39205      | Машин, тоног төхөөрөмж            | 956,965,951.97          | 896,499,875.82          |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл             | (553,584,577.01)        | (586,116,559.93)        |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил       | 236,399,507.00          | 217,007,495.50          |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл             | (121,767,313.66)        | (122,286,443.72)        |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө              | 67,954,121.00           | 77,247,581.00           |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл             | (42,066,443.54)         | (47,797,409.70)         |
| 39217      | Номын фонд                        | 4,028,400,118.96        | 4,144,836,964.80        |



|          |  |                         |                         |
|----------|--|-------------------------|-------------------------|
| 393      | Биет бус хөрөнгө   | <b>51,368,662.40</b>    | <b>57,316,729.31</b>    |
| 39301    | Програм хангамж  | 23,950,000.00           | 28,950,000.00           |
| 39302    | Хасагдуулга  | (4,789,999.92)          | (7,393,333.22)          |
| 39303    | Бусад биет бус хөрөнгө                                   | 47,636,000.00           | 57,636,000.00           |
| 39304    | Хасагдуулга  | (15,427,337.68)         | (21,875,937.47)         |
| <b>3</b> | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                | <b>5,036,701,564.71</b> | <b>5,024,335,286.74</b> |
| <b>4</b> | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>                             | <b>11,815,434.66</b>    | <b>6,932,403.80</b>     |
| 41       | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                                | 11,815,434.66           | 6,932,403.80            |
| 413      | Өглөг  | 11,815,434.66           | 6,932,403.80            |
| 4131     | Ажиллагчидтай холбогдсон өглөг                           | 122,953.56              | 309,079.25              |
| 4132     | Бараа үйлчилгээний зардлын өглөг                         | 2,977.00                | 2,977.00                |
| 4136     | Бусад өглөг  | 11,689,504.10           | 6,620,347.55            |
| 41361    | Байгууллагад төлөх өглөг                                 | 11,143,797.10           | 6,251,475.55            |
